

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕБС-ИЙН 7А АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 60 минут

Хувилбар-А

Нийт 20 оноо

2024.06.04

ХӨРӨГ НАЙРУУЛАЛ

Модод гөлөглөчихжээ. Цоо шинэхэн, гэрэлтсэн ногоон өнгөтэй нахианууд хачин уярам сэтгэгдэл төрүүлэхэд, яагаад ч юм бэ, намхан биетэй, буурал толгойтой, үргэлж л нүүрэндээ мишээл тодруулан намайг угтдаг эмээ минь бодогдов ...

Эмээ уншиж чаддаггүй байсан юм. Аймгийн төвд орж ирснийхээ дараа радио их сонсдог болжээ. Эмээ минь дуучдыг хоолойгоор нь андахгүй таньдаг, тэр үеийн улсуудын удирдагчдын нэрс, за тэгээд, аль нь социалист, аль нь хөрөнгөтөн орон болохыг ялгаж мэддэг авай. Эмээ их олон үлгэр мэддэг байсан мөртлөө, яагаад ч юм бэ, надад ерөөсөө ярьж өгч байгаагүй. Гэхдээ эмээ минь “Гучин хоёр модон хүн”-ий үлгэрийг харин бүгдийг нь мэддэг.

Эмээ дууг бол харин зааж өгдөг байлаа. Тухайн үед ихэд дэлгэрч, хэн хүнгүй аялдаг болчихсон дууны үгийг надад зөвтгөн хэлж өгдөг хүн ганцхан эмээ л байсан юм... Намайг ухаан суухын хэрээр эмээгийн хоолой аргиж, би “Дааган хар” хэмээх дууны өөр аль ч нутагт дуулдаггүй бэсрэгдүүхэн аяыг л цээжилж амжсан. Заримдаа “Дааган хар”-ыг эмээгийнхээ аялдаг барилаар аялж үзэхдээ ерөөсөө өөр нэг ч хүн энэ дууг ингэж дуулдаггүй байх гэж боддог юм. ...

1. Гадаад шинжийг тодруулан гаргасан тэмдэг нэрсийг түүж, дотоод шинжийг дүгнэн бичээрэй. /2 оноо/

Гадаад шинж	Дотоод шинж

2. Дээрх эхийн үйл явдал ямар улиралд болж байна вэ? /1 оноо/

.....
 Ямар өгүүлбэрээр илэрхийлэгдэж байна вэ? /1 оноо/

3. Дараах үгийн утгыг тайлбарлан бичнэ үү. /0.5 оноо/

Цээжээ уудлах-

Дараах тэмдэг нэрийг харьцуулсан зэрэгт хувирган бичээрэй /1.5 оноо/

Тэмдэг нэр	Ижил зэрэг	Илүү зэрэг	Давуу зэрэг
цагаан			

4. Дараах үгийг бүтээврээр задалж, бүтээвр тус бүрийг нэрлээрэй. /2 оноо/

Хүсэлд-

5. Үгсийг бичээд зөв бичих дүрмийг тайлбарлана уу. /2 оноо/

А. Ном+л=.....
 Б. Тос+л=

6. Халхын дөрвөн ханы нэр болон тэдний хийсэн үйлдлийг нөхөн бичээрэй. /5 оноо/

Цол	Хийсэн үйлдэл
Сайн ноён хан	
	Эмээлийг нь ойчих вий гэж түшсэн
Цэцэн хан	

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

1. Өмнөд хэсэгт халхын ноён хан
 2. Өмнөд хэсэгт халхын ноён хан
 3. Өмнөд хэсэгт халхын ноён хан
 4. Өмнөд хэсэгт халхын ноён хан
 5. Өмнөд хэсэгт халхын ноён хан
 6. Өмнөд хэсэгт халхын ноён хан

ДОРНОД АЙМГИЙН ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЕБС-ИЙН 7А АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 60 минут

Хувилбар-Б

Нийт 20 оноо

2024.06.04

МУ-ЫН ГАВЬЯАТ ЖУЖИГЧИН Б.ЦЭРЭНПАГМА

Цагаан цамц, хуниастай урт хар банзал өмсөж, үсээ ардаа сулхан боосон, ид сайхан насандаа яваа, нүд дүүрэн эмэгтэй товор товор алхан айсуу. Киноныхон дунд үлгэр домог шиг үлдсэн, цуутай хүүхэн... Уруул дээрх мэнгэ, инээхэд нь ярс хийх цагаан шүд, илүү дутуу хиймэл зан авиргүй байгаагаараа...

Гучин жил зүтгэсэн, арилж баларшгүй томоос том орон зайг эзэлсэн, дунд үеийн лидер жүжигчдийн нэг шүү дээ гэж бухимдмаар. Зан чанарын хувьд Б.Цэрэнпагма бусадэмэгтэйчүүдээс тэс ондоо. Нялхамсуу, танхил, ад мөрийн шинж юу ч байхгүй.

Хээ шаагүй, атаа жөтөөгүй, алдаж онохоос сийхгүй, дур зоргоороо.

Бүсгүй хүний заяа төөрөг, гуниг баяр, дурлал хайр, хагацал зовлонгоос яаж ангид байхав. Энэ бүхнийг тэр аяглаж, аргалж, захалж, эрхэлж туулсангүй. Гудиггүй туучаад л гарсан.

1. Эхээс гадаад, дотоод шинжийг тодорхойлон бичээрэй

/2 оноо/

Гадаад шинж	Дотоод шинж

2. Эхэд Цэрэнпагмын цагтаа алдар цуутай байсан гэсэн санааг юутай адилтгасан байна вэ?

/1

оноо/

Тухайн өгүүлбэрийг ялган бичнэ үү.

/1 оноо/

3. Дараах үгийн утгыг тайлбарлан бичнэ үү.

/0.5 оноо/

Цээж сайтай-

Дараах тэмдэг нэрийг харьцуулсан зэрэгт хувирган бичээрэй

/1.5 оноо/

Тэмдэг нэр	Ижил зэрэг	Илүү зэрэг	Давуу зэрэг
Хатуу			

4. Дараах үгийг бүтээврээр задалж, бүтээвр тус бүрийг нэрлээрэй.

/2 оноо/

Орлогоор-

5. Үгсийг бичээд зөв бичих дүрмийг тайлбарлана уу.

/2 оноо/

А. Тор+л=

Б. Бат+л=

6. Зохиолыг агуулгын хэсгийг уншиж зохиолын нэрийг бичээрэй.

/5 оноо/

Зохиолын хэсэг	Зохиолын нэр
Хөдөөгийн байдал шалдар булдар...	
...Алтан сайхан эмээлээ	
Аялгуу тааруулан магтмуу...	
...Өвлийн жаварт өглөө аав, хүү хоёулаа уйлж явлаа.	
...Өдөр явсан явдлыг шөнө шүүгтэн	
Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун...	

7. Дараах өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй.

/5 оноо

1. Өдөр явсан явдлыг шөнө шүүгтэн
 2. Алтан сайхан эмээлээ
 3. Аялгуу тааруулан магтмуу...
 4. Хөдөөгийн байдал шалдар булдар...
 5. ...Өвлийн жаварт өглөө аав, хүү хоёулаа уйлж явлаа.
 6. Ичгүүр гэмт явдлыг ятгаж орхигтун...
 7. Дараах үгийг бүтээврээр задалж, бүтээвр тус бүрийг нэрлээрэй.
 8. Үгсийг бичээд зөв бичих дүрмийг тайлбарлана уу.
 9. Дараах тэмдэг нэрийг харьцуулсан зэрэгт хувирган бичээрэй.
 10. Цээж сайтай-